



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/688

Ховд

Хязгаарлалт тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в" заалт, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.1.17 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 12 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Нийслэл Улаанбаатар хотод Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын сэжигтэй тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан Ховд аймгийн нутаг дэвсгэрээс орох, гарах нийтийн болон хувийн тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 08:00 цагаас 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 23:00 цаг хүртэлх хугацаанд хязгаарласугай.

2. Нийтийн тээвэр болон хувийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт хийж хэрэгжилтийг хангаж ажиллахыг Онцгой комиссын орлогч, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /дэд хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /хурандаа Э.Даваасүрэн/, Автотээврийн төв /Н.Ирэхзаяа/, Жаргалант сумын Засаг дарга бөгөөд Ховд хотын захирагч /С.Гантөмөр/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хяналтын пост, цэгүүдийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үүрэг гүйцэтгэж байгаа мэргэжлийн байгууллагуудын алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж, хоол хүнс, аюулгүй байдлыг хангуулах заавар зөвлөмж өгч ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /дэд хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Автотээврийн төв /Н.Ирэхзаяа/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, Эрүүл мэндийн газар /Ц.Мягмарсүрэн/, Ховд хотын захирагч бөгөөд сумын Засаг дарга /С.Гантөмөр/ нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 3091  
D/Zax-A/688-Bo